



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дөргөн сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/107/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Ховд хот

2023 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нарантуул

Утас: 99019800

Цахим хаяг: narantuul.d@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.5.1 Төсвийн төлөвлөлт	13
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	13
3.5.3 Нэмэлт төсөв	
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн	
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.5 Завсрын аудитын талаар 2022 онд завсрын аудит хийгдээгүй, өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилтийг хянасан	15
4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5.1 Залруулсан алдаа	
5.2 Төлбөрийн акт	16
5.3 Зөвлөмж	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ДӨРГӨН СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА М.ХӨХНОХОЙ ТАНАА

2023.02.20 № 2/60
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дөргөн сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дөргөн сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, эмийн болон шатахууны зардлын зарцуулалтад дотоод хяналт хэрэгжүүлээгүй, эд хариуцагчийн тайлан гаргалт хангалтгүй анхан шатны баримтыг ажил гүйлгээ гаргасан, цалингийн урьдчилгаа олгоод суутган аваагүй, хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт илүү эдлүүлсэн, амралтын цалин илүү олгосон зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуй нэгж байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй, "Тохиолдсон байх", "Иж бүрэн байх", "Нийцсэн бөгөөд зохистой байх", "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Эрүүл мэндийн төв нь тусгай зориулалтын шилжүүлгээс буюу улсын төсвөөс санхүүждэг байсан 2022 онд иргэдэд үзүүлсэн эмнэлгийн тусламж үйлчилгээний тарифаар тооцон Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилтийг олгодог болсон нь нэг иргэнээр тооцсон санхүүжилт, үндсэн тусламж үйлчилгээний санхүүжилт, нэмэлт орлогын эх үүсвэрээр санхүүжих зарчимд шилжсэн байна.

Аудитын гол асуудал

021020150

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээгүй болно.

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант онд 5 зорилтын хүрээнд 10 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийг 84.6 хувийн биелэлттэй гэж дүгнэгдсэн байна.

Дөргөн сумын эрүүл мэндийн төв нь сумын 680 гаруй өрхийн 2419 гаруй иргэнд давхардсан тоогоор 3461 амбулаторийн үзлэгт хамруулж 233 иргэнийг хэвтүүлэн эмчилж 1639 ор хоног, дундаж ор хоног 7, орны фонд ашиглалт 46 хувьтай, 235 алсын дуудлагад үйлчилж, 50 гаруй эх төрүүлсэн статистик үзүүлэлттэй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Х.БОЛДБААТАР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	81,257,343.40	201,101,431.34
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,966,643	127,877,211.49
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	2,966,643	127,877,211.49
3121	Төгрөг	2,966,643	-
31211	Төрийн сангийн харилцах	2,966,643	-
3122	Гадаад валют	-	127,877,211.49
31221	Төрийн сангийн харилцах	-	127,877,211.49
33	АВЛАГА	28,637,051.55	1,885,080
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,326,340.55	43,169
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	25,961,500	-
335	Бусад авлага	1,349,211	1,841,911
3351	Байгууллагаас авах авлага	649,211	1,141,911
3352	Хувь хүмүүсээс авах авлага	700,000	700,000
34	УРЬДЧИЛГАА	100,000	-
3471	Урьдчилгаа тооцоо	100,000	-
34713	Цалингийн урьдчилгаа	100,000	-
35	БАРАА МАТЕРИАЛ	49,553,648.85	71,339,139.85
351	Түүхий эд материал	11,234,291.45	12,433,482.45
35130	Эм боох материал	11,234,291.45	12,433,482.45
354	Хангамжийн материал	38,319,357.40	58,905,657.40
35410	Бичиг хэргийн материал	154,500	-
35420	Аж ахуйн материал	37,415,157.40	57,579,667.40
35460	Хүнсний материал	749,700	1,325,990
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	328,136,540.23	366,394,063.12
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	328,136,540.23	366,394,063.12
392	Биет хөрөнгө	312,119,690.31	350,468,613.24
39201	Барилга, байгууламж, орон сууц	259,032,109.06	259,032,109.06
39202	Хуримтлагдсан элэгдэл	(32,725,352.64)	(43,845,753.96)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	40,214,222	91,137,554
39204	Хуримтлагдсан элэгдэл	(28,579,110.87)	(37,935,731.66)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	175,446,627.56	188,771,052.56
39206	Хуримтлагдсан элэгдэл	(107,239,224.72)	(127,664,636.60)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	18,568,132.00	34,433,132.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(12,847,212.08)	(13,708,612.16)
39217	Ном	249,500	249,500
393	Биет бус хөрөнгө	16,016,849.92	15,925,449.88
39301	Программ хангамж	732,000	732,000
39302	Хуримтлагдсан элэгдэл	(549,200.08)	(640,600.12)
39303	Бусад биет бус хөрөнгө	15,834,050	15,834,050

3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>409,393,883.63</u>	<u>567,495,494.46</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>4,190,130.05</u>	<u>433,650</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,190,130.05	433,650
413	Өглөг	4,190,130.05	433,650
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	563,202	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	2,555,928.05	433,650
4136	Бусад өглөг	1,071,000	-
41361	Байгууллагад төлөх өглөг	1,071,000	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>405,203,753.58</u>	<u>567,061,844.46</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	405,203,753.58	567,061,844.46
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	191,439,640	191,439,640
51101	Өмч: - төрийн	191,439,640	191,439,640
512	Хуримтлагдсан үр дүн	(64,304,588.48)	97,553,502.40
51210	Өмнөх үеийн үр дүн	(64,304,588.48)	(66,537,760.03)
51220	Тайлант үеийн үр дүн		164,091,262.43
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	278,068,702.06	278,068,702.06
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>409,393,883.63</u>	<u>567,495,494.46</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	576,337,828.46	731,317,152.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	33,504,813.46	96,751,911
120	Нийтлэг татварын бус орлого	33,504,813.46	96,751,911
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	33,504,813.46	96,421,911
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	602,500	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	32,902,313.46	96,421,911
120009	Бусад орлого	-	330,000
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	542,833,015	634,565,242
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	383,466,600	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	11,544,400	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	371,922,200	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	31,433,223	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30,830,723	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	602,500	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	21,615,842	45,289,731.60
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	21,615,842	45,289,731.60
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	106,317,350	589,275,510
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	106,317,350	589,275,510
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	567,113,556.26	567,225,890.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	567,113,556.26	567,225,890.17
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	537,513,556.26	567,225,890.17

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	310,532,056	305,279,676.47
210101	Үндсэн цалин	310,532,056	305,279,676.47
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,547,328.50	39,038,060.54
210201	Тэтгэврийн даатгал	27,131,506.26	27,167,008.04
210202	Тэтгэмжийн даатгал	3,105,320.56	3,028,850.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,484,256.45	2,423,080.48
210204	Ажилгүйдлийн даатгал	615,604.11	549,877.86
210205	Эрүүл мэндийн даатгал	6,210,641.12	5,869,243.56
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,330,442	42,531,135.60
210301	Гэрэл, цахилгаан	1,582,242	1,793,797.60
210302	Түлш, халаалт	18,748,200	40,737,338
2104	Хангамж, бараа материалын зардал	34,538,900	36,483,150
210401	Бичиг хэрэг	3,071,350	-
210402	Тээвэр, шатахуун	25,288,900	33,110,450
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,491,000	2,883,000
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,396,150	489,700
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	291,500	-
2105	Нормативт зардал	88,347,571.80	72,324,115.45
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	76,611,682.80	58,103,975.45
210502	Хоол, хүнс	10,556,550	14,220,140
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,179,339	-
2107	Томилолт, зочны зардал	237,000	1,048,000
210702	Дотоод албан томилолт	237,000	1,048,000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,343,750	1,306,674
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	288,750	582,450
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000	-
210803	Даатгалын үйлчилгээ	300,000	424,450
210804	Тээврийн хэрэгслийн татвар	25,000	84,200
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	80,000	25,000
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	450,000	190,574
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	42,636,507.96	69,215,078.11
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,576,388	27,359,844
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	34,060,119.96	41,855,234.11
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,600,000	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,600,000	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	29,600,000	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>9,224,272.20</u>	<u>164,091,262.43</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>9,224,272.20</u>	<u>164,091,262.43</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>544,026,915</u>	<u>660,856,741.60</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,193,900	330,000
120	Нийтлэг татварын бус орлого	1,193,900	330,000
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	602,500	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	602,500	-
120009	Бусад орлого	591,400	330,000
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	542,833,015	660,526,741.60
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	383,466,600	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	11,544,400	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	371,922,200	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	31,433,223	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30,830,723	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	602,500	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	21,615,842	45,289,731.60
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	21,615,842	45,289,731.60
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	106,317,350	615,237,010
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	106,317,350	615,237,010
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>528,913,372</u>	<u>535,946,173.11</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	528,913,372	535,946,173.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	499,313,372	535,946,173.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	308,863,936	298,330,421.01
210101	Үндсэн цалин	187,359,358	188,690,119.86
210102	Нэмэгдэл	94,333,778	71,159,910.15
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,292,000	4,963,449
210104	Урамшуулал	21,878,800	33,516,942
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,602,032	44,173,300
210201	Тэтгэврийн даатгал	30,851,632	30,066,700
210202	Тэтгэмжийн даатгал	2,937,600	3,500,900
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,350,100	2,831,300
210204	Ажилгүйдлийн даатгал	587,500	706,800
210205	Эрүүл мэндийн даатгал	5,875,200	7,067,600
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,876,842	42,531,135.60
210301	Гэрэл, цахилгаан	1,682,242	1,793,797.60
210302	Түлш, халаалт	18,748,200	40,737,338
210303	Цэвэр, бохир ус	446,400	-
2104	Хангамж, бараа материалын зардал	31,109,059	49,507,750
210401	Бичиг хэрэг	1,912,650	5,611,700
210402	Тээвэр, шатахуун	24,133,171	33,941,150
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,563,238	3,070,000

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,500,000	3,029,300
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	3,855,600
2105	Нормативт зардал	83,680,318	83,687,342.50
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	71,399,418	62,833,912.50
210502	Хоол, хүнс	9,495,500	14,796,430
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,785,400	6,057,000
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,939,000	7,789,500
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,000,000	6,020,000
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	1,356,500
210604	Урсгал засвар	939,000	413,000
2107	Томилолт, зочны зардал	237,000	1,048,000
210702	Дотоод албан томилолт	237,000	1,048,000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,105,000	4,648,974
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	3,924,750
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000	-
210803	Даатгалын үйлчилгээ	300,000	424,450
210804	Тээврийн хэрэгслийн татвар	25,000	84,200
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	80,000	25,000
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	500,000	190,574
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,900,185	4,229,750
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,900,185	4,229,750
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,600,000	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,600,000	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	29,600,000	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>15,113,543</u>	<u>124,910,568.49</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	15,113,543	124,910,568.49
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		2,966,643
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,966,643	127,877,211.49

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	191,439,640	278,068,702.06	(87,185,142.15)	382,323,199.91
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	191,439,640	278,068,702.06	(87,185,142.15)	382,323,199.91
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	22,880,553.67	22,880,553.67
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	191,439,640	278,068,702.06	(64,304,588.48)	405,203,753.58
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	191,439,640	278,068,702.06	(64,304,588.48)	405,203,753.58

D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(2,233,171.55)	(2,233,171.55)
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	191,439,640	278,068,702.06	(66,537,760.03)	402,970,582.03
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	164,091,262.43	164,091,262.43
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	191,439,640	278,068,702.06	97,553,502.40	567,061,844.46

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	646,892,800	535,946,173.11	110,946,626.89	82.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	646,892,800	535,946,173.11	110,946,626.89	82.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	646,892,800	535,946,173.11	110,946,626.89	82.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	280,155,300	298,330,421.01	(18,175,121.01)	106.49
210101	Үндсэн цалин	157,851,600	188,690,119.86	(30,838,519.86)	119.54
210102	Нэмэгдэл	80,980,600	71,159,910.15	9,820,689.85	87.87
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,567,500	4,963,449	2,604,051	65.59
210104	Урамшуулал	33,755,600	33,516,942	238,658	99.29
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,019,200	44,173,300	(9,154,100)	126.14
210201	Тэтгэврийн даатгал	23,916,100	30,066,700	(6,150,600)	125.72
210202	Тэтгэмжийн даатгал	2,771,400	3,500,900	(729,500)	126.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,224,900	2,831,300	(606,400)	127.26
210204	Ажилгүйдлийн даатгал	555,200	706,800	(151,600)	127.31
210205	Эрүүл мэндийн даатгал	5,551,600	7,067,600	(1,516,000)	127.31
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	59,141,400	42,531,135.60	16,610,264.40	71.91
210301	Гэрэл, цахилгаан	2,051,200	1,793,797.60	257,402.40	87
210302	Түлш, халаалт	56,543,800	40,737,338	15,806,462	72
210303	Цэвэр, бохир ус	546,400		546,400	-
2104	Хангамж, бараа материалын зардал	58,323,500	49,507,750	8,815,750	84.88
210401	Бичиг хэрэг	6,313,500	5,611,700	701,800	88.88
210402	Тээвэр, шатахуун	39,010,000	33,941,150	5,068,850	87.01
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,100,000	3,070,000	1,030,000	74.88
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,500,000	3,029,300	1,470,700	67.32
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,400,000	3,855,600	544,400	87.63
2105	Нормативт зардал	174,277,500	83,687,342.50	90,590,157.50	48.02
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	153,501,000	62,833,912.50	90,667,087.50	40.93
210502	Хоол, хүнс	14,193,000	14,796,430	(603,430)	104.25
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,583,500	6,057,000	526,500	92.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,369,100	7,789,500	2,579,600	75.12
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,416,500	6,020,000	1,396,500	81.17
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,000,000	1,356,500	643,500	

210604	Урсгал засвар	952,600	413,000	539,600	43.36
2107	Томилолт, зочны зардал	4,359,000	1,048,000	3,311,000	24.04
210702	Дотоод албан томилолт	4,359,000	1,048,000	3,311,000	24.04
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,116,000	4,648,974	3,467,026	57.28
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,000,000	3,924,750	2,075,250	65.41
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	533,500		533,500	-
210803	Даатгалын үйлчилгээ	425,000	424,450	550	100
210804	Тээврийн хэрэгслийн татвар	90,500	84,200	6,300	93
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	58,500	25,000	33,500	43
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	300,000		300,000	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	708,500	190,574	517,926	26.90
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,131,800	4,229,750	12,902,050	24.69
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,131,800	4,229,750	12,902,050	24.69
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	646,892,800	660,856,741.60	(13,963,942)	102.16
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	62,533,200	45,289,731.60	17,243,468	72.43
132001	Орон нутгийн төсвөөс	62,533,200	45,289,731.60	17,243,468	72.43
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	584,359,600	615,237,010	(30,877,410)	105.28
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	584,359,600	615,237,010	(30,877,410)	105.28
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	330,000	(330,000)	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		330,000	(330,000)	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		2,966,643	(2,966,643.00)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		127,877,211.49	(127,877,211)	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	22	22	-	100
620001	Удирдах ажилтан	1	1	-	100
620002	Гүйцэтгэх ажилтан	16	16	-	100
620003	Үйлчлэх ажилтан	4	4	-	100
620004	Гэрээт ажилтан	1	1	-	100

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дөргөн сумын Эрүүл мэндийн төв нь “Үйлчлүүлэгчийн эрх, хэрэгцээг хангасан тусламж үйлчилгээ үзүүлэх” гэсэн эрхэм зорилгын хүрээнд ард иргэдэд чанартай тусламж үйлчилгээ үзүүлэх, эрүүл мэндийн боловсрол олгох, үйлчлүүлэгчдэд тав тухтай орчин бий болгох гэсэн зорилтыг тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөх Төрийн хэмнэлтийн тухай хууль шинээр батлагдаж мөрдөж эхэлсэн байна. Дараах тогтоолуудыг үйл ажиллагаандаа мөрдөж байна. Үүнд:

- Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай ”
- Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай “
- Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай”

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дөргөн сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “ДУНД” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналтгүй гэж үзлээ

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дөргөн сумын Эрүүл мэндийн төв нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 9.6 сая төгрөгөөр буюу 2.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая.төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	3.0	127.9	124.9
Авлага	28.7	1.9	(26.8)

Бараа материал	49.6	71.3	21.7
Үндсэн хөрөнгө	328.1	366.4	38.3
Нийт хөрөнгө	409.4	567.5	158.1
Өр төлбөр	4.2	0.4	(3.8)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	405.2	567.1	161.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	409.4	567.5	158.1

Дансны үлдэгдэлд гарсан дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- ✓ Байгууллага нь гүйцэтгэлээр санхүүждэг болсны дагуу Сангийн яамны 2022 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 18 дугаар тоот албан бичгээр хүргүүлсэн чиглэлийн дагуу мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 127.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй өмнөх оноос 124.9 сая төгрөгөөр өссөн байна.
- ✓ Өмнөх онд Эрүүл мэндийн даатгалын сангаас төлбөртэй үйлчилгээний авлага 26.0 сая төгрөг байсныг тайлант онд санхүүжилтээр авч барагдуулж оны эцэст 1.9 сая төгрөгийн авлага нь байгууллага, ажиллагсадаас авах авлага байна.
- ✓ Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 21.7 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд Эрүүл мэндийн газраас үнэ төлбөргүй нэг удаагийн эмнэлгийн хэрэгсэл, аймгийн Онцгой байдлын газраас 200 ширхгийг 2.4 сая төгрөгийн ковидын оношлуур, тестийг үнэ төлбөргүйгээр, хувь хүнээс 225 ширхэг оношлуурыг 2.9 сая төгрөгөөр худалдан авсан тайлант оны эцэст 4.7 сая төгрөгийн 376 ширхэг тестийг зарцуулаагүйгээс үлдэгдэлтэй байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны орон нутгийн төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 62.5 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 480.6 сая төгрөг бүгд 543.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлж тайлант оны эхэнд 545.5 сая төгрөгөөр баталж, оны эцэст 649.2 сая төгрөгөөр тодотгон баталжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын сангаас 615.2 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 45.3 сая төгрөг, ЭМГ-аас 0.3 сая төгрөг нийт 660.8 сая төгрөгийн санхүүжилт авч орон нутгийн төсвөөс 19.6 сая төгрөгийн санхүүжилт дутуу, ЭМДС-аас өмнөх оны 25.9 сая төгрөгийн санхүүжилтийг авч 535.9 сая төгрөгийн зардал гаргасан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая. төгрөгөөр/

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
71602- Эмнэлгийн тусламж үйлчилгээ					
1	71602/80302- Нэг иргэнд ногдох нормативаар	333.8	333.8	-	100.0
2	71602/81603- Үндсэн мэргэжлийн тусламж	170.5	233.7	(63.2)	137.1

3	71602/83603- Нэмэлт- дээд шатны төсвөөс хуваарилсан	40	48.1	(8.1)	120.3
4	71602/80111- Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	62.5	42.9	19.6	68.6
5	71602/80112- Нийтлэг үйлчилгээ	2.4	2.3	0.1	95.8
ДҮН		609.2	660.8	-51.6	108.5

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар өмнөх оны санхүүжилтийн авлага 25.9 сая төгрөгийг ЭМДС-аас авч улсын төсвийн дансанд төвлөрүүлэн зарцуулсан тул нэмэлт санхүүжилтийн тайлан тусгайлан гаргаагүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дөргөн сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг ахлах аудитор Д.Нарантуул 2023 оны 02 дугаар сарын 18-наас 02 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 05 албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 567.3 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 8.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 5.9 сая төгрөгөөр тогтоож гүйцэтгэлийн шатанд шинэчлэн тогтоогоогүй болно.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Ховд аймгийн Дөргөн сумын ЭМТөв нь энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан тэргүүн дэд, дэд, орлогч дарга, 7 дугаар зүйлд заасан албан тасалгаа, 8 дугаар зүйлд заасан дүрэмт хувцас, 9 дүгээр зүйлд албан томилолт, 10 дугаар зүйлд цалин хөлс, нэмэгдэл, 14 дүгээр зүйлд заасан цахим худалдан авалт, 15 дугаар зүйлд хэмнэлтийн бусад арга хэмжээтэй холбоотой заалтууд хамаарахгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хуулийн 6.4.5-д заасны дагуу тайлант онд орлого, зарлагын ажил гүйлгээг бүрэн мэдээлсэн, 2022 оны хагас жилийн санхүүгийн тайланг PDF хэлбэрээр оруулаагүй байна.

4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 61.3 сая төгрөгийн 1.1 сая төгрөгийн төлбөрийн акт, 2.9 сая төгрөгийн албан шаардлага, 57.3 сая төгрөгийн 2 зөвлөмж өгөгдөж хэрэгжилт 36 хувьтай байна.

Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	1.1	2	1.1	100
Албан шаардлага	1	2.9	-	-	-
Зөвлөмж	2	57.3	1	4.5	7.9
Нийт дүн	5	61.3	3	5.6	36

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар онцлон анхаарах асуудал аудит хийх явцад эм болон шатахууны зарцуулалтыг авч үзэх нь гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 765.4 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад алдааг залрууллаа. Үүнд:

- Аймгийн Онцгой байдлын газраас 2022 оны 8 сард нэг бүр нь 12.0 мянган төгрөгийн үнэтэй 200 ширхэг буюу 2.4 сая төгрөгийн түргэвчилсэн оношлуурыг орлогод аваагүй,
- Тайлант оны хөрөнгийн элэгдлийн зардлыг 3.3 сая төгрөгөөр дутуу,
- Мөнгөн гүйлгээний болон санхүүгийн үр дүнгийн тайланд орлогыг 713.9 сая төгрөгөөр илүү бүртгэсэн,
- Бараа материалын үлдэгдлийг 4.9 сая төгрөгөөр илүү ,
- Авлага 1.8 сая төгрөгөөр дутуу, өглөг 0.7 сая төгрөгөөр илүү тусгасан,
- Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг 24.9 сая төгрөгөөр илүү тайлагнасан,
- Тайлант үеийн үр дүнг 13.5 сая төгрөгөөр илүү тайлагнасныг аудитын явцад залруулсан.

Аудитаар нийт 99.5 сая төгрөгийн зөрчил² илэрснээс 0.9 сая төгрөгийн төлбөрийн акт, 98.6 сая төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

Амралтын цалин илүү олгосон, урьдчилгаа цалин олгоод шууд зардлаар тайлагнасан, ХХОАТ-ын хөнгөлөлт илүү эдлүүлсэн зэрэгтэй холбоотой 0.9 сая төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16.5.1-д “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; ”16.5.4.төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх; 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэсэн заалттай нийцээгүй”, Хувь хүний албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д “Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ”, гэсэн заалттай нийцээгүй, “Тохиолдсон байх”, “Иж бүрэн байх”, “Нийцсэн бөгөөд зохистой байх”, “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.2 Зөвлөмж

5.2.1 Анхан шатны баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын хэрэгцээний автомашиныг Улаанбаатар хотоос авч ирэх зардлын анхан шатны баримт бүрэн бус, эд хариуцагчийн дансаар дамжуулан анхан шатны баримтгүй ажил гүйлгээ гаргасан, бүрэн бус томилолтын хуудсаар томилолтын мөнгө олгосонд 3.6 сая төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16.5.1.төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; ”16.5.4.төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.6-д “анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хориглоно", 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтгүй ажил гүйлгээ гаргахгүй байх,

5.2.2 Бараа материалын данстай холбоотой

Илрүүлэлт Тайлант онд 92.4 сая төгрөгийн эм, шатахуун худалдан авсан, эмийн болон шатахууны тайлан гаргалт хангалтгүй, жолоочийн тооцоог сар бүр бодоогүй, шатахууны зарцуулалтад тавих хяналт хэрэгжүүлээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 16.5.1.төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; "16.5.4.төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх;", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.Сангийн сайдын 2017 оны 347 дүгээр тушаалын НХМаягт БМ-9-д "бараа материалын тайланг нярав, эд хариуцагч нь аж ахуйн нэгж байгууллагын бүртгэлийн бодлогын баримт бичигт заасан хугацаанд агуулахын бүртгэлд үндэслэн материалын нэр төрөл тус бүрийн тоо хэмжээгээр нэгтгэн гаргана. Бараа материалын тайланг нярав, эд хариуцагч нар дээр хөтлөгдөж буй агуулахын бүртгэлтэй тулган шалган хүлээж авна", НХМаягт ТМ-4-д Жолоочийн тооцооны хуудас, Тухайн байгууллагын хөнгөн тэрэг нь ямар албан тушаалтны хэрэгцээнд үйлчилсэн талаарх гүйцэтгэлийг гаргахдаа жолоочийн тооцооны хуудсыг хэрэглэнэ. Хөнгөн тэрэг хэрэглэсэн албан тушаалтан хэдэн км явснаа хянаад гарын үсэг зурна. Тооцоог нягтлан бодогч хийж, нийт дүнгээр түлш, шатахууны хэмнэлт, хэтрэлтийг гаргана" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж Бараа материалын тайланг сар бүр гаргах, жолоочийн тооцоог бодож хэвших

5.2.3 Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тендерийн эмийн худалдан авалт, зарцуулалтын тооцоог хийлгэхээр эм зүйчтэй гэрээ байгуулж ажлын хөлс олгосон, хоолны зардлаас ахмадуудыг үйл ажиллагаанд 2.6 сая төгрөгийг зарцуулсан, хугацаа дууссан эм, эм эмнэлгийн хэрэгсэлд хяналт хэрэгжүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах;" 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх;", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж : Эм, эмийн худалдан авалт, зарцуулалтад дотоод хяналт хэрэгжүүлэн, төсвийг үр ашигтай зарцуулах талаар анхааран ажиллах

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөг/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс	
							Залруулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үнэ төлбөргүй шилжүүлсэн хөрөнгийг дутуу бүртгэсэн	1	2.4	1	2.4			1	2.4

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл зөрүүтэй тусгасан	1	24.9			1	24.9	1	24.9
Тайлант үеийн үр дүн дутуу илэрхийлсэн	1	13.5			1	13.5	1	13.5
Мөнгөн гүйлгээний тайланд орлого зөрүүтэй илэрхийлсэн	1	713.9	1	713.9			1	713.9
Авлага тооцоо нийлээгүй, тайлант оны эцэст авлага тусгаагүй орхигдуулсан	1	1.8			1	1.8	1	1.8
Өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, санхүүгийн тайланд хасах тэмдэгтэй илэрхийлсэн	1	0.7			1	0.7	1	0.7
Тайлант онд зарцуулсан шатахууныг үлдэгдлээр тайлагнасан	1	4.9			1	4.9	1	4.9
Тайлант оны хуримтлагдсан элэгдлийн зардал дутуу тусгасан	1	3.3	1	3.3			1	3.3
Дүн	8	765.4	3	719.6	5	45.8	8	765.4

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ сая төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалингийн урьдчилгаа олгоод авлагаар бүртгээгүй шууд зардалд хаасан, ХХОАТ-ын хөнгөлөлт илүү эдлүүлсэн, амралтын цалин илүү олгосон	1	0.9	1	0.9				
Анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил гүйлгээ гаргасан	1	3.6					1	3.6
Эмийн болон шатахууны тайлан гаргалт хангалтгүй дотоод хяналт хэрэгжүүлэн ажиллаагүй	1	92.4					1	92.4
Тендерээр нийлүүлсэн эмийн худалдан авалт, зарцуулалтын тооцоог хийлгэхээр эм зүйтэй гэрээ байгуулан ажлын хөлс олгосон, хоолны зардлаас бусад зардалд зарцуулсан, хугацаа дууссан эм, эм эмнэлгийн хэрэгсэлд хяналт хэрэгжүүлээгүй	1	2.6					1	2.6
Дүн	4	99.5	1	0.9	-	-	3	98.6

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2023 оны 02 сарын 02 өдөр

Дугаар 16/A2160424

Ховд

ХОА-2022/107/НА/-СТА-ТШЗ
ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дөргөн сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланд аудитаар амралтын цалин илүү олгосон, урьдчилгаа цалин олгоод шууд зардлаар тайлагнасан, ХХОАТ-ын хөнгөлөлт илүү эдлүүлсэн зэрэгтэй холбоотой 923.3 мянган төгрөгийг зарцуулсан зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; "16.5.4.төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх; 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалттай нийцээгүй", Хувь хүний албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д "Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлднэ", гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дээрх зөрчилтэй холбоотой 923312 /есөн зуун хорин гурван мянга гурван зуун арван хоёр төгрөгийг/-ийг төлүүлэн Төрийн сангийн бусад нэр зааж ангилагдаагүй орлогын 100160000955 тоот дансанд 2023 оны 06 дугаар сарын 15-ны дотор төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 20-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дөргөн сумын Эрүүл мэндийн төвийн дарга М.Хөхнохой, нягтлан бодогч Т.Цэцэгчүлүүн нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.БОРДБААТАР

АХЛАХ АУДИТОР

Д.НАРАНТУУЛ

¹ Монгол Улс, Ховд аймаг, Жаргалант сум, Цамбагарав баг, Засаг даргын Тамгын газрын байр, 3 давхар Утас: 70433061